

## Компанийн товч танилцуулга

Ард даатгал ХК нь 1994 онд үүсгэн байгуулагдаж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасан шаардлагуудыг ханган Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2/16 тоот даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч 30 гаруй жил үйл ажиллагаа явуулж буй Хувьцаат Компани юм.

2018 онд IPO гарган Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани болсон. 2025 оны жилийн эцсээр 9,200 орчим хувьцаа эзэмшигчтэй байна.

Өдгөө Монгол Улсын даатгалын салбарт тэргүүлэгч байр суурь бүхий олон улсад болон дотоодод нэр хүндтэй, тогтвортой даатгалын үйлчилгээ үзүүлэгч болсон төдийгүй баялаг бүтээгчдийн найдвартай ар тал болон дэмжиж ажилласаар ирсэн нь улсынхаа эдийн засаг, нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмрээ оруулан амжилттай ажиллаж байгааг харуулж байна.

## Хувьцаа эзэмшигчид


**62.2%** Ард Санхүүгийн Нэгдэл\*

**37.8%** Бусад

\*Ард санхүүгийн нэгдэл болон түүний хамаарал бүхий компаниуд

### Хувьцааны мэдээлэл

MSE:AIC



Хаалтын ханш:  
(12.31.2025)

**₮ 7279**

Нийт хувьцааны тоо:

**25 сая**

Нийт арилжаалагдсан:

**763,523**

Зах зээлийн үнэлгээ:

**₮ 18.2 тэрбум**

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТООГООР

**#1**

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ЖИЛ

**+30**



НИЙТ АЖИЛТНЫ ТОО

**+100**

ХАМТРАН АЖИЛЛАДАГ ЗУУЧЛАГЧ

**+70**

ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН

**+50**

САЛБАРЫН ТОО

**21**

ХАМТРАН АЖИЛЛАДАГ АРИЛЖААНЫ БАНК

**5**

ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ТОО

**180K**

ХУРААМЖИЙН ОРЛОГО

**40** ТЭРБУМ

ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨРИЙН ТОО

**12.1K**

ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨР


**20** ТЭРБУМ

**ISO:9001**  
СТАНДАРТ НЭВТРҮҮЛСЭН



**ISO:27001**  
СТАНДАРТ НЭВТРҮҮЛСЭН

## Түүхэн замнал



## Даатгалын үйлчилгээ

Ард даатгал ХК нь ердийн даатгалын компани бөгөөд албан журмын даатгалаас гадна сайн дурын 50 гаруй төрлийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдадаа санал болгож байна. Бид жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, малын индексжүүлсэн даатгал, газар тариалангийн даатгал, баталгааны даатгалыг анхлан хэрэгжүүлэгчдийн нэг билээ.



## Давхар даатгал

Ард даатгал компани дотоодод хийгдсэн даатгалын гэрээг Англи, Америк, Герман, Япон, Сингапур, Швейцар зэрэг олон улсын өндөр үнэлгээ бүхий давхар даатгалын томоохон компаниудад тогтмол даатгуулж ирсэн туршлагатай билээ.

Бид ХБНГУ-ын Алианс компанитай стратегийн түншлэлийн хүрээнд урт хугацааны туршид хамтран ажиллаж байна. Мөн Ханновер Ре, Монголиан Ре, Свисс Ре зэрэг компаниуд нь манай байнгын хамтран ажилладаг давхар даатгагч бөгөөд бид өөрсдийн эрсдэлийн багцыг факультатив болон трити гэрээ байгуулан давхар даатгуулдаг.

● Давхар даатгалын хураамж: (сая төгрөг)

ФАКУЛЬТАТИВ	3,527 сая ₮	ФРОНТИНГ	3,481 сая ₮	ТРИТИ	595 сая ₮
-------------	-------------	----------	-------------	-------	-----------

Хураамж	2024	%	2025	%
Факультатив	3,163	44%	3,527	46%
Фронтинг	3,150	44%	3,481	46%
Трити	838	12%	595	8%
<b>Нийт</b>	<b>7,150</b>	<b>100%</b>	<b>7,602</b>	<b>100%</b>

Даатгалын хэлбэр	Хураамж	%	Нөхөн төлбөр	%
Хөрөнгө, тээвэр	2,300	30%	1,840	100%
Хариуцлага	1,911	25%	-	-
Бусад	3,391	45%	-	-
<b>Нийт</b>	<b>7,602</b>	<b>100%</b>	<b>1,840</b>	<b>100%</b>

## Эрүүл мэндийн даатгал


Бид **Ард-Мэнд** дотоодын эрүүл мэндийн даатгал, **Ard-Medicare (Ard-Med)** олон улсын эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг санал болгон 150 мянга гаруй харилцагчдад эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалын үйлчилгээг үзүүлж, харилцагчдын тоо өсөн нэмэгдлээ.

Ard-Medicare олон улсын эрүүл мэндийн даатгал нь дэлхийн 200 гаруй оронд 330 мянга гаруй гэрээт эмнэлгүүдээр үйлчлүүлэх өргөн сүлжээ бүхий олон улсын **MSH China** эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагатай хамтран ажиллаж, хэрэгжүүлдэг бүтээгдэхүүн юм.

Манай харилцагчдын хувьд олон улсын эрүүл мэндийн даатгалын шууд төлбөрийн (direct billing) үйлчилгээг Азийн улсууд болон БНХАУ, Солонгос, Япон, Тайланд, Монгол болон Австрали, Герман, Швед, Швейцар зэрэг дэлхийн улс орнууд дахь сүлжээ эмнэлгүүдээр үйлчилгээ авсан байна.

## Баталгааны даатгал

Ард даатгал компани нь Даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсны дагуу даатгагчийн баталгааг үзүүлж эхэлсэн.



■ Даатгалын салбар ■ Ард Даатгал ХК

## Нөхөн төлбөрийн үйлчилгээ

2025 онд Малын индексжүүлсэн даатгалаар нийт **101.4 сая** төгрөгийн нөхөн төлбөр олгосон. Худалдаа хөгжлийн банктай байгуулсан цалингийн зээлийн даатгалаар нийт **175** даатгуулагчид **1.1 тэрбум** төгрөгийн нөхөн төлбөр олгосон. Ард даатгал ХК нь даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр олголтоор салбартаа тэргүүлдэг.

Даатгалын хэлбэр	Нийт нөхөн төлбөр (сая ₮)			Даатгуулагчийн тоо (мянга)		
	2024	2025	Өөрчлөлт	2024	2025	Өөрчлөлт
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	2,440	2,129	▼ -13%	2,193	2,576	▲ 17%
Хөрөнгийн даатгал	497	2,160	▲ 335%	215	170	▼ -21%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	3,861	4,461	▲ 16%	2,470	2,103	▼ -15%
Ачааны даатгал	67	104	▲ 55%	10	12	▲ 20%
Хариуцлагын даатгал	279	166	▼ -41%	61	85	▲ 39%
Зээлийн даатгал	2,456	1,083	▼ -56%	266	171	▼ -36%
Жолоочийн албан журмын даатгал	9,366	9,848	▲ 5%	7,782	6,965	▼ -10%
Бусад	697	75	▼ -89%	1	3	▲ 200%
<b>Нийт</b>	<b>19,663</b>	<b>20,026</b>	<b>▲ 2%</b>	<b>12,998</b>	<b>12,085</b>	<b>▼ -7%</b>
Өдөрт шийдвэрлэсэн нөхөн төлбөрийн тоо		50			52	

## Санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)

	Нийт хураамж	Нийт нөхөн төлбөр	Давхар даатгал	Нийт хөрөнгө	Нөөц сан	Цэвэр ашиг	Хохирлын харьцаа*	Зардлын харьцаа**	Хосолсон харьцаа
2023	32,438	14,095	5,660	44,156	22,367	3,277	41%	56%	97%
2024	45,244	19,663	7,150	51,133	26,912	2,410	49%	49%	98%
2025	40,465	20,026	7,602	57,077	23,139	3,063	47%	56%	103%

\*Цэвэр нөхөн төлбөр / Орлогод тооцсон хураамж

\*\*Үйл ажиллагааны зардал / Орлогод тооцсон хураамж

## Даатгалын багц мэдээлэл (сая төгрөг)

Даатгалын хэлбэр	Нийт хураамж			Даатгуулагчийн тоо (мянга)		
	2024	2025	Өөрчлөлт	2024	2025	Өөрчлөлт
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	5,320	4,822	▼ -9%	24.5	24.6	▲ 0.4%
Хөрөнгийн даатгал	6,487	6,617	▲ 2%	17.5	17.2	▼ -2%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	12,062	9,483	▼ -21%	17.1	10.5	▼ -39%
Ачааны даатгал	427	375	▼ -12%	0.2	0.9	▲ 350%
Барилга угсралтын даатгал	2,303	1,511	▼ -34%	0.02	0.016	▼ -20%
Хариуцлагын даатгал	4,372	5,308	▲ 21%	0.7	0.9	▲ 29%
Жолоочийн албан журмын даатгал	11,874	8,124	▼ -32%	194.7	121.9	▼ -37%
Бусад	2,399	4,225	▲ 76%	2.8	4.0	▲ 43%
<b>Нийт</b>	<b>45,244</b>	<b>40,465</b>	<b>▼ -11%</b>	<b>257.5</b>	<b>180.0</b>	<b>▼ -30%</b>

## Онцлох үйл явдал

✓ Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO/IEC 27001:2022 олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, сертификатыг хүлээн авснаар олон улсад түгээмэл хэрэглэгдэж буй тайлагналын дараах стандарт, аргачлалуудыг нэгэн зэрэг нэвтрүүлэн ажиллаж байгаа Монгол Улсын анхдагч даатгалын компани боллоо. Үүнд:

- Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын нягтлан бодох бүртгэлийн тайлагналын IFRS 17 стандарт;
- Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөлийн (SASB) стандарт
- Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO/IEC 27001:2022 стандарт

- ✓ Даатгалын салбарт 2 дах удаа “Тогтвортой хөгжлийн тайлан 2024” тайланг гаргалаа.
- ✓ Даатгалын гэрээний хугацаанд нөхөн төлбөр аваагүй даатгуулагч иргэдийг Ард Койн-оор урамшуулах ажлыг зохион байгуулж нийт 73.7 мянга гаруй даатгуулагч иргэнд 650.0 сая төгрөгтэй тэнцэх 10.9 сая ширхэг Ард койныг олгосон байна.
- ✓ Даатгуулагч, харилцагчийн дуу хоолойг сонсох, санал хүсэлт, гомдол мэдээллийг системтэйгээр хүлээн авч, дүн шинжилгээ хийх замаар үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах зорилтын хүрээнд “Харилцагчийн үйлчилгээний төв”-ийг шинэчлэн зохион байгуулсан.
- ✓ Ослын дуудлагыг цахимсаар авч, бүртгэн баталгаажуулах үйлчилгээг нэвтрүүлснээр даатгуулагчийн цагийг хэмнэх, замын түгжрэлийг бууруулахад чиглэсэн алхам боллоо.

## Ердийн даатгалын зах зээл

Даатгагчийн тоо: 18	Зах зээл <sup>①</sup>	Зах зээлийн дундаж	Ард Даатгал
Даатгалын нийт хураамж	575,711	31,984	▲ 40,465
Давхар даатгалын хураамж	195,235	10,846	▼ 7,602
Даатгалын цэвэр хураамж	360,954	20,053	▲ 31,296
Орлогод тооцсон хураамж	345,954	19,220	▲ 36,506
Нийт нөхөн төлбөр	189,075	10,504	▲ 20,026
Цэвэр нөхөн төлбөр	148,692	8,261	▲ 16,994
Үйл ажиллагааны зардал	197,032	10,946	▲ 20,532
Нийт хөрөнгийн дүн	674,442	37,469	▲ 57,077
Нөхөн төлбөрийн нөөц сангийн дүн	73,316	4,073	▲ 6,006
Эздийн өмчийн дүн	269,583	14,977	▲ 22,456
Хохирлын харьцаа <sup>②</sup>	56%	-	47%
Зардлын харьцаа <sup>③</sup>	60%	-	56%
Хосолсон харьцаа <sup>④</sup>	116%	-	103%

① СЗХ-ны “Даатгалын салбарын 2025 оны жилийн эцсийн үйл ажиллагааны нэгдсэн тайлангаас

## Сонирхолтой судалгаа

- ✓ 2025 онд тээврийн хэрэгслийн даатгалын хураамж 9.5 тэрбум төгрөг, Жолоочийн даатгалын хураамж 8.1 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд 9731 даатгалын тохиолдлоор 14.3 тэрбум төгрөгийн хохирлыг шийдвэрлэсэн нь компанийн нийт нөхөн төлбөрийн 71 хувийг эзэлж байна. Нөхөн төлбөрийг өмнөх онтой харьцуулбал:


Даатгалын хэлбэр	Нөхөн төлбөрийн хэмжээ (сая ₮)		Нөхөн төлбөрийн тоо		Дундаж нөхөн төлбөр (сая ₮)	
	2024	2025	2024	2025	2024	2025
Жолоочийн даатгал	9,365	9,847	7,782	7,461	1.2	1.3
Тээврийн хэрэгслийн даатгал	3,860	4,460	2,470	2,270	1.6	2.0
<b>Нийт</b>	<b>13,226</b>	<b>14,308</b>	<b>10,252</b>	<b>9,731</b>		

- ✓ Даатгалын тохиолдлын 90 орчим хувь нь “зам тээврийн хөдөлгөөнд оролцох үеийн мөргөлдөх, шүргэлдэх, онхолдох зэрэг эрсдэл” байна. Нийт хохирлын 80 хувийг тус компанийн хохирол баталгаажуулалтаар, 20 хувийг ТЦГ-ын ослын баталгаажуулалтаар тус тус шийдвэрлэсэн байна.


- ✓ Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйлчилгээ үзүүлэгч 17 даатгалын компани байдаг бөгөөд 2025 оны жилийн эцсийн тайлангийн байдлыг графикаас харж болно.

- ✓ 2025 онд даатгалын зах зээлд Жолоочийн даатгалын 26 мянган тохиолдлоор 47.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон бол Ард даатгал компани 7.5 мянган харилцагчид 9.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгожээ. Энэ нь олгосон нөхөн төлбөрийн дүнгээр зах зээлийн 21%-ийг эзэлж байна. Зөвхөн Жолоочийн даатгалаар ажлын өдөр бүр 30 даатгуулагчид 40.0 орчим сая төгрөгийн нөхөн төлбөр олгож байна гэсэн тооцоо гарчээ.

ЖД-ын хураамж (тэрбум.₮)



ЖД-ын нөхөн төлбөр (тэрбум ₮)



■ Бусад даатгагч ■ Ард Даатгал ХК

### Хаяг:

1710 тоот, 17 давхар, Сэнтрал тауэр, Сүхбаатарын талбай-2, 8 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Монгол улс - 14-200

☎ 7720-0088

🌐 www.arddaatgal.mn



Ард Апп татах:

